Усны газрын 2026 оны 01 дугаар сарын 05-ны өдрийн
01/3 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

УСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5		0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**3.5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(варсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд томдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөделгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өрөвдөл, томдлын хувийн жингээр тооцно)*		1	2	20
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**4**	**40**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**10.5**	**100**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

ЗӨВШӨӨРСӨН:
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

2025 оны ..... сарын.....

БАТАЛСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Д.САЙХАНЖАРГАЛ

2025 оны 04 сарын 20

УСНЫ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтод түвшин	Хугацаа /улирал/	Хариуцах гишүүн
Зорилт 1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах							
1	Арга хэмжээ 1.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах	-	Хууль тогтоомжийг албан хаагчдад сурталчлан таниулсан арга хэмжээний тоо	-	1	I-II	Нийт гишүүд
		-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	1	II-III	Г.Ичинхорлоо
2	Арга хэмжээ 1.2."Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт тусгуулсан байдал /тийм-1, үгүй-0/	-	1	I-II	Д.Жаргал
3	Арга хэмжээ 1.3.Ёс зүйн хороо болон байгууллагын удирдлагаас ирүүлсэн чиг үүргийг тухай бүрд нь хэрэгжүүлж ажиллах	-	Нийт ирүүлсэн чиг үүргээс хэрэгжүүлсэн чиг үүргийн эзлэх хувь	-	100	I-IV	Нийт гишүүд
Зорилт 2. Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хэрэгжүүлэх							
4	Арга хэмжээ 2.1.Дэд хорооны хуралдааныг улирал бүр 2-оос доошгүй удаа зохион байгуулах	-	Зохион байгуулсан хуралдааны тоо	-	4	I-IV	Нийт гишүүд
5	Арга хэмжээ 2.2.Үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийж байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж, эсхүл албан хаагчид зөвлөмж хүргүүлэх	-	Үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлсон дүгнэлтийн тоо	-	1	II	Нийт гишүүд

6	Арга хэмжээ 2.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.1-д заасны дагуу гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгаж, шийдвэрлэнэ	-	Ирүүлсэн нийт гомдол мэдээллийг хуулийн хугацаанд хянан шалгаж, шийдвэрлэсэн хувь	-	100	I-IV	Нийт гишүүд
7	Арга хэмжээ 2.4.Ёс зүйн зөрчлийг шалгаж, шийдвэрлэсэн тухай бүрд дүгнэлт гаргаж байгууллагын даргад хүргүүлэх	-	Шалгаж шийдвэрлэсэн нийт гомдол мэдээллийн хүрээнд дүгнэлт гаргаж хүргүүлсэн хувь	-	100	I-IV	Нийт гишүүд
8	Арга хэмжээ 2.5.Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийх	-	Шалгаж шийдвэрлэсэн нийт гомдол мэдээлэл, гаргасан дүгнэлт, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид байгууллагын удирдлагаас ноогдуулсан хариуцлагын талаарх мэдээллийг цахим системд оруулсан хувь	-	100	I-IV	Нийт гишүүд
9	Арга хэмжээ 2.6.Ёс зүйн дэд хорооны ажлын тайланг Ёс зүйн хороонд улирал бүр хүргүүлэх.	-	Хүргүүлсэн тайлангийн тоо	-	4	I-IV	Нийт гишүүд

---oOo---

Усны газрын 2026 оны ..01.. дугаар сарын ..05..ны
өдрийн ..01/3.. дугаар албан бичгийн хоёрдугаар
хавсралт

УСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга[1]

Усны газрын Ёс зүйн дэд хорооноос 2025 онд Төрийн албан албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”, Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг нийт албан хаагчдад танилцуулах, хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хамтран ажиллалаа.

1.Усны газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг 9 заалт бүхий арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн Ёс зүйн дэд хорооны дарга батлан, Усны газрын даргаар зөвшөөрч, Ёс зүйн хорооны https://hrm.csc.gov.mn/ethics/planning/822 цахим системд үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 арга хэмжээ, сургалтын төлөвлөгөөнд 3 арга хэмжээ төлөвлөн ажилласан.

2. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

3.Усны газрын веб хуудсанд Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа гэсэн цэсийг нэмж Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд байршуулсан шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас зэрэг мэдээллээр баяжуулан, байгууллагын мэдээллийн самбар, үүдний хэсэг, албан хаагчдын өрөө бүрд авлигаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны материалыг байршуулсан.

4. Авлигатай тэмцэж газраас олон нийтэд ил болгосон “Шударга байдлын үнэлгээ-2024” судалгааны тайлантай танилцан Байгууллагын шударга байдлын үнэлгээг сайжруулах 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээнүүдийн явцын зорилтод түвшинд хамаарах гүйцэтгэлийг гаргаж дүгнэхэд 84.2 хувийн гүйцэтгэлтэй буюу хүрсэн түвшин 90 хувьтай байна.

5. Ёс зүйн дэд хорооны гишүүн Г.Ичинхорлоо ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор Усны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/127 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж Усны чанар, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Батзаяа, Хууль тогтоомж, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Жаргал, Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Оюунтөгс нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:
1. Авлигатай тэмцэх газартай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр нийт албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх болон ХАСХОМ-ийг бөглөх журмын талаар сургалт орж сургалтад 23 албан хаагчийг хамруулсан. 2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад 2025.03.27-28-ны өдрүүдэд 4 албан хаагч оролцсон. 3. "Эрдэнэжамц сан" ТББ-тай хамтран 2025.04.10-ны өдөр нийт албан хаагчдад сэтгэл зүй болон ёс зүйн талаарх сургалт орж зөвлөгөө өгсөн. 4. 2025.12.24-ний өдөр "Хандлагаа өөрчилье" сэдэвтэй хэлэлцүүлгийг нийт албан хаагчдын дунд зохион байгуулж, байгууллагын дотоодод үүссэн дутагдалтай талуудыг хэрхэн даван туулах, хамтран ажиллах талаар хэлэлцсэн.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
1. Усны газрын даргын тушаалаар Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшуулалт цалинг улирал тутамд олгохоор тушаал гаргаж шийдвэрлэж, урамшууллыг олгосон. 2. Усны газраас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх 7 төрлийн төрийн үйлчилгээ болох дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг 2024 оны 04 дүгээр сараас эхлэн цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлснийг 2025 онд бүрэн цахим болгосон. Энэ нь дүгнэлт гаргах үйл ажиллагааг төрийн албан хаагчийн үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр цахим системд боловсруулан шийдвэрлэх хэлбэрт шилжүүлснээрээ ил тод, нээлттэй байдал хангагдаж албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж байна. 3. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Архивын улсын үзлэгтэй холбоотойгоор шалгалт хийж буй эрх бүхий албан тушаалтнаас байгууллага цахим сүлжээ, мэдээлэл, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах программ ашигладаг эсэх талаар асуухад "Тэр хогоор яадаг юм" гэх үг хэллэг хэрэглэн хүндэтгэлгүй, зохисгүй байдлаар хариулж, байгууллагын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлсэн, мөн байгууллагын даргын онлайн хурал зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах үүргээ биелүүлээгүй, Zoom программын ашиглалтын эрхийг сунгуулаагүй, удирдлагын шаардлагыг үл хүндэтгэн зохисгүй үг хэллэг хэрэглэж, ажлын байраа орхисон Мэдээллийн технологи, цахим систем хариуцсан ажилтан О.Ононг албан тушаалаас нь түдгэлзүүлэх тушаал гарган зөрчлийг Ёс зүйн дэд хороонд шилжүүлэн шалгуулж, Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
1.Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд заасны дагуу ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хүрээнд 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр албан хаагчдаас ёс зүйн талаарх, ойлголт мэдлэгийг шалгах асуулгыг тестээр авч нэгтгэн дүнг даргад танилцуулан ажиллалаа. 2. Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас"-аар 2025.12.27-ны өдөр нийт албан хаагчдаас судалгаа авч үнэлгээ хийж, танилцуулгыг газрын даргад танилцуулсан. 3. Дээр дурдсан төлөвлөгөөнд заасан 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

4. 2025 онд албан хаагчдын ёс зүйн талаарх 2 гомдол мэдээллийг хүлээн авч, шалгаад ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр 1 гомдол мэдээллийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлж, 1 гомдол мэдээлэлд буюу Мэдээллийн технологи, цахим систем хариуцсан ажилтан О.Ононг ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэж дүгнээд хариуцлага тооцуулахаар дүгнэлтийг газрын даргад хүргүүлсэн. Дүгнэлтийг үндэслэн тухайн албан хаагчийг албан тушаалаас халах шийдвэр гарсан.

Эдгээр гомдол мэдээлэлтэй холбоотой баримт, явцын мэдээлэл болон дүгнэлт, шийдвэрийг Ёс зүйн хорооны https://hrm.csc.gov.mn/ethics/violationcomplain системд тухай бүрд нь оруулсан. Бүртгэлийн дугаар: 2520729-1330, 251217-1509

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хэм хэмжээ, үндэсний хөтөлбөрийг албан хаагчдад танилцуулж, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлсэн. 2. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг Ёс зүйн хорооны цахим системд бүрэн төлөвлөж, тайлагнасан. 3. Ёс зүйн соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажил идэвхтэй хэрэгжсэн 4. Байгууллагын үндсэн үйл ажиллагааг ил тод, цахим шилжилтийг ахиулсан 5. Ёс зүйн зөрчилд хариуцлагатай, шуурхай хандаж, ёс зүйн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч шалгаж шийдвэрлэдэг тогтолцоог бий болгосон 6. Шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр тодорхой ахиц гарсан	1. Зарим албан хаагчийн зүгээс удирдлага, хяналт шалгалтын байгууллагад хүндэтгэлгүй, зохисгүй үг хэллэг хэрэглэсэн, үүрэг даалгаврыг биелүүлээгүй ноцтой зөрчил гарсан нь албан хаагчдын ёс зүйн ухамсар, харилцааны соёл жигд биш байна. 2. Ёс зүйн зөрчил нэг тохиолдолд албан тушаалаас халах шийдвэрт хүрсэн нь урьдчилан сэргийлэх ажлыг илүү эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. 3. Ёс зүйн дэд хорооны гишүүн солигдож, бүрэлдэхүүн шинэчлэгдсэн нь тодорхой хугацаанд ажлын залгамж чанарт нөлөөлөх эрсдэл дагуулсан.

Санал:

1. Ёс зүйн сургалт, хэлэлцүүлгийг жил бүр төлөвлөгөөтэй зохион байгуулж, шинэ болон эрсдэл өндөртэй албан тушаалд ажиллагсдад чиглэсэн зорилтот сургалтыг нэмэгдүүлэх.
2. Ёс зүйн эрсдэлийн үнэлгээний дүнг албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, дотоод хяналтын үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх.
3. Цахим орчинд ажиллах сахилга бат, мэдээллийн аюулгүй байдлын талаарх дотоод журам, хяналтыг чангатгах.
4. Гишүүдийн чадавхыг бэхжүүлэх, залгамж чанарыг хангах, Ёс зүйн хорооны цахим системд мэдээлэл оруулах, тайлагнах ажлыг тасралтгүй, чанартай хэрэгжүүлэх.

Шалгах хэсэг:

- ☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

Ёс зүйн дэд хорооны дарга:
УСНЫ ЧАНАР, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА У.БАТЗАЯА

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:
ХУУЛЬ ТОГТООМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛ